



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Аймгийн татварын хэлтийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн

**БАТЛАГДСАН ТӨСӨВТӨӨ БАГТААН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН БАЙНА**

Өлгий

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар	3
Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган	Бүлэг 1 1.1 Аймгийн Татварын хэлтсийн бүтэц орон тоог баталж ажиллаагүй байна.	6
Аудитын менежер Х.Женисбек	1.2 Хэлтсийн үйл ажиллагааны төсвийг өмнөх оны гүйцэтгэлийг харгалзаж төлөвлөсөн байна.	7
Ахлах аудитор М.Айнур	1.3 Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.	8
Аудитор Р.Баярмаа	1.4 Нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулж ирсэн байна.	10
2018 оны 6 дугаар сар	Бүлэг 2 2.1 Байгууллагын үйл ажиллагаанд зохих журмаар хяналт тавьж ажилласан байна.	11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 94156768 дугаарын утсаар харилцана уу	2.2 Өмч хөрөнгийн ашиглалт, төсвийн зарцуулалтанд зохих түвшинд хяналт тавьж ажилласан байна.	12
ХАЯГ:	Дүгнэлт	13
Аймгийн ЗДТГазрын байр 1 дүгээр давхар 108 тоот өрөө	Зөвлөмж: Зөвлөмж өгөгдөөгүй	
	Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	
	Саналд өгсөн тайлбар	

Товчилсон үгийн тайлбар

ТЕГ	Татварын ерөнхий газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компант
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэл зүйлс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт

ҮАГ-ын харьяа Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Татварын хэлтсийн 2017 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж, гарсан зөрчил, дутагдлыг арилгах, цаашид засаж сайжруулах санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Татварын хэлтсийн үйл ажиллагааг үр ашигтай төлөвлөж хэрэгжүүлсэн эсэх
- Дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх

Хамарсан хүрээ

Энэхүү аудитад аймгийн Татварын хэлтсийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон ажлын тайлан, баримт материал, бусад тооцоо судалгаа үйл ажиллагаануудыг хамрууллаа.

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, харилцан ярилцлагад тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ. /Хавсралт №1/

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Аудитын Олон Улсын Стандарт (АДБОУС 300), Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам, аудитын арга зүйг ашиглан, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, тайлбар лавлагаа авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Асуудлын талаар товч мэдээлэл

Аймгийн Татварын хэлтэс нь төсвийн орлого бүрдүүлэх төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг, орлого бүрдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьдаг чиг үүрэг бүхий байгууллага юм.

Аймгийн Татварын хэлтэс нь 2017 оны 12 сарын 31-ний мэдээгээр 449 аж ахуйн нэгж байгууллага, 206 нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байгууллага, 441 төсөвт байгууллага, 20919 татварын төлөгч иргэнтэй харилцаж үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Аймгийн Татварын хэлтэс нь 2017 онд 545,1 сая төгрөгийн төсвөөр төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд орон нутгийн төсвөөс 16,7 сая төгрөгийн санхүүжилт авсныг орон тооны бус байцаагчдын цалин болон тоног төхөөрөмж худалдан авахдаа зарцуулсан байна. Харьяа дээд байгууллагаас 1,0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Тайлант оны үйл ажиллагаатай холбоотой өр үүсгээгүй байна.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- 2017 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг ахлах аудитор М.Айнур, аудитор Р.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг төлөвлөгөө, хөтөлбөрийн хуваарийн дагуу хэрэгжүүлж, аудитын тайланг бэлтгэв. Аудитын тайлангийн хавсралт судалгаа мэдээнүүдийг тайланд хавсаргасан болно.

Бүлэг 1

*Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа
явуулсан байна.*

1. Татварын хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн талаар.

1.1. Татварын хэлтсийн 2017 оны бүтэц, орон тоо тооны төлөвлөлтийн талаар.

Татварын хэлтсийн бүтэц орон тоог баталж, ажиллаагүй байна.

Аймгийн Татварын хэлтсийн бүтэц орон тоог Татварын Ерөнхий газраас хянаж баталж ирсэн байна. Татварын Ерөнхий газар 2016 онд Гаалийн ерөнхий газартай нийлж, бүтэц орон тооны өөрчлөлтөд орсноор аймгийн Татварын хэлтсийн нийт 42 ажилтныг Татварын Ерөнхий газрын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Б/192 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар чөлөөлж, мөн өдрийн Б/192 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар ажилд эргүүлэн томилсон байна.

Татварын хэлтсийн урьд ажиллаж байсан болон шинээр томилогдсон дарга нарын тушаалыг тусдаа гаргаж, баталж ирүүлжээ.

Татварын Ерөнхий газраас Гаалийн ерөнхий газартай нийлэхэд аймгийн Татварын хэлтсийн орон тооны хязгаарыг 2016 онд 38 хүнээр баталсан байна. Харин 2017 онд бүтэц орон тооны өөрчлөлтөөр Гаалийн ерөнхий газраас буцаад салснаас хойш орон тооны хязгаарыг баталж ирүүлээгүй байна.

Тус хэлтэс 2017 онд гүйцэтгэлээр 44 орон тоо ажиллуулсан бөгөөд орон тооны хязгаарыг баталж ирүүлээгүйгээс гүйцэтгэлийг нь харьцуулах боломжгүй байна.

Татварын хэлтсийн даргын тушаалаар 2017 онд бүтэц, орон тоог батлаагүй, цалинг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн

байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг зөрчиж байна.

Татварын Ерөнхий газрын 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 906 тоот тушаалаар “Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэст орон тооны бус байцаагч ажиллуулах журам”-ыг баталсан байна.

Уг журмын 1.2-т “орон тооны бус байцаагчийн цалин хөлс, үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ”, 1.4-т “орон тооны байцаагчийн цалин хөлс нь тухайн Татварын албаны батлагдсан төсөвт хамаарахгүй” гэж заасан байна.

Журмын 2.1 д “... орон тооны бус байцаагчийн тооны хязгаарыг тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж баталсан төсөвт багтааж харьяалах албаны дарга тогтооно” гэж заажээ.

Орон тооны байцаагч ажиллуулах талаар аймгийн ИТХ-ын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 16 тоот тогтоолоор аймагт ажиллах орон тооны байцаагчийн цалин, аймгийн Татварын хэлтсийн тоног төхөөрөмж худалдан авах зардалд нийт 16,7 сая төгрөгийг баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/460 тоот захирамжаар орон нутгийн төсвийн үлдэгдлээс орон тооны бус байцаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл болон тоног төхөөрөмж, бичиг хэргийн санхүүжилтэд 16,7 сая төгрөгийг олгохоор заасан байна.

Татварын хэлтэс нь 2017 онд Цагааннуурын боомт, Өлгий сумын төвд 3-6 сарын хугацаатай 9 орон тооны бус байцаагчийг ажиллуулсан байна.

Орон тооны байцаагчдын цалинг нийт оруулсан орлогын 25 хүртэл хувиар олгохоор тусгаж, тайлант онд орон тооны бус байцаагчдын цалин хөлсөнд 8,8 сая төгрөгийг олгожээ. Орон тооны бус байцаагчид орон нутгийн төсөвт тайлант онд 30,3 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Аудитын дүнгээр батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг баталж ажиллаж байхыг албан шаардлагаар үүрэг болголоо.

1.2. Урсгал зардлын төсвийн төлөвлөлтийн талаар.

Хэлтсийн үйл ажиллагааны төсвийг өмнөх оны гүйцэтгэлийг харгалзаж төлөвлөсөн байна.

Аймгийн Татварын хэлтсийн 2017 оны батлагдсан төсвийг анх 526,2 сая төгрөгөөр баталж ирүүлжээ. Төсвийн тодотголоор хэлтсийн төсвийг 545,1 сая төгрөгөөр баталж, анх баталснаас 18,9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Үүнд: Цалингийн санг 4,5 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 3,0 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 0,5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 1,0 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 11,4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 0,4-1,1 сая төгрөгөөр бууруулсан байна.

Хэлтсийн 2017 оны төсвийг урьд оны төсөвтэй харьцуулахад 41,2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төрийн албан хаагч нарт олгох нэг удаагийн урамшууллын 11,4 сая төгрөгийг хасаж тооцвол үйл ажиллагааны төсөв өмнөх оноос 29,8 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна.

Тодруулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 26,7 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,3 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 1,9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 0,5-3,7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

2017 оны гүйцэтгэлээр үйл ажиллагаатай холбоотой өр, авлага үүсгээгүй байна. Үүнээс үзэхэд тус хэлтсийн төсвийг урьд оны гүйцэтгэлийг харгалзан төлөвлөсөн байна.

1.3. Батлагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар.

Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Татварын хэлтэс нь 2017 оны гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 545,1 сая төгрөгийн төсөв зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Зардлын зүйл ангиар авч үзвэл цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийг төсөвтөө багтаан зарцуулжээ.

Татварын хэлтсийн 2017 оны цалингийн санд нийт 431,6 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 431,6 сая төгрөг зарцуулж, төсөвтөө багтаан ажилласан байна. Урамшуулалт цалингийн төсвийг 1,0 сая төгрөгөөр хэтрүүлснийг үндсэн цалингаас санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 44 орон тоог цалингийн сандаа багтааж ажиллуулж, орон тооны бус 9 байцаагчийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж ажиллуулжээ. Төрийн албан хаагч нарт олгох урамшууллыг зохих журмаар олгосон байна.

Тайлант онд цалингийн сангийн төсвөөс аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн зохих зөвшөөрөлгүйгээр 11,6 сая төгрөгийг бусад зардалд зориулалт бусаар гүйлгэн зарцуулсан байна.

Тухайлбал: Хэлтсийн даргын А/16 дугаар тушаалаар Наурыз баярын арга хэмжээнд 0,6 сая төгрөг, Мартын 8 баярын арга хэмжээнд 0,1 сая төгрөг, А/36 дугаар тушаалаар Эх үрсийн баярын арга хэмжээнд 0,5 сая төгрөг, А/33 дугаар тушаалаар татвар төлөгчдийн арга хэмжээнд 0,5 сая төгрөг, А/34 дугаар тушаалаар сургалт семинарын зардалд 1,5 сая төгрөг, А/52 дугаар тушаалаар 0,5 сая төгрөг, баруун бүсийн уулзалтад 5,0 сая төгрөг, А/65 дугаар тушаалаар Санхүүчдийн баярын арга хэмжээнд 0,4 сая төгрөг, бусад урсгал зардалд 2,5 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Энэхүү зардлын зарим хэсгийг баяр ёслолын арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулж Монгол Улсын Их хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 2 дугаар хэсгийн 2.в-д “төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэсэн заалт мөн Сангийн Сайдын 2013 оны Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 4 дэх хэсгийн 4.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авсан байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоог сар бүр хийж ирсэн боловч худалдан авсан шатахууныг няравын тайлан хөтөлж орлогод авч, зарцуулалтыг нь тайлагнаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.3.2-т “журналд бичих” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Ажилтнуудын цалинг цалингийн картаар тавьж олгодог ба банкны теллерээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна. Цалин тавьж олгох хүснэгтэд ажилтнуудын танилцсан гарын үсгийг зуруулаагүй байгаа дутагдлыг цаашид засаж сар болгон ажилчдад танилцаж гарын үсэг зуруулж байхыг зөвлөв.

Нийгмийн даатгалын шимтгэл, Хувь хүний орлогын албан татварыг хуулийн дагуу суутгаж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, татварын тайланг холбогдох байгууллагуудад хугацаанд нь өгч ажилласан байна.

Хувь хүний орлогын албан татварын ногдуулалт, төлөлтийн тооцоог цалингийн цэс болон сар бүрийн төлөлттэй тулгаж үзэхэд зөрүү гараагүй.

Нийгмийн даатгалын шимтгэлийн ногдуулалт, төлөлтийн тооцоог хийж үзэхэд 5 дугаар сард ажилчдад олгосон 4,5 сая төгрөгийн урамшуулалт

цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд оруулалгүй орхигдуулсан зөрчил илэрлээ.

Татварын хэлтсийн нь бараа үйлчилгээний зардалд 102,1 сая төгрөгийн төсөв батлагдаж, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Бараа үйлчилгээний зардлыг нийт дүнгээр төсөвтөө багтаан зарцуулсан боловч хангамжийн материал, байр ашиглалттай холбоотой, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 1,0-33,4 мянган төгрөгөөр хэмнэж, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардлыг 49,7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Аудитын явцад гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, тээвэр шатахуун, шуудан холбоо, дотоод томилолт, бичиг хэргийн зардлуудын гүйцэтгэлийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй байна.

Аудитын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах албан шаардлага өгч, санхүүчдийн баярын билетийн үнэд олгосон 0,4 сая төгрөгийг нэр бүхий ажилтнуудаар, урамшуулалд ногдох 0,9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагын төсвөөс нөхөн төлүүлэхээр тус тус төлбөрийн акт тогтоов.

1.4. Нэмэлт төсвийн санхүүжилтийн зарцуулалтын талаар

Нэмэлт төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн Засаг даргын А/460 дугаар захирамжийн дагуу Санхүү төрийн сангийн хэлтсээс Татварын хэлтсийн орон тооны бус байцаагчдын цалин, шимтгэл, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардлын санхүүжилтэд 16,7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн эрхийг нээж, үүнээс цалинд 10,5 сая төгрөг, НДШ-д 1,2 сая төгрөг, бичиг хэрэгт 0,5 сая төгрөг, тээвэр шатахуунд 0,5 сая төгрөг, Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлд 4,0 сая төгрөг зарцуулахыг зөвшөөрсөн байна.

Гүйцэтгэлээр цалин, НДШ-д 10,9 сая төгрөг, тээвэр шатахуунд 0,5 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0,5 сая төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 4,0 сая төгрөг, байгууллагын бусад үйл ажиллагаанд 1,0 сая төгрөг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг тусдаа тайлагнаж, орон тооны бус байцаагчдын цалин, тушаал шийдвэр бусад холбогдох анхан шатны баримтуудыг бүрдүүлж, баримт болгон үдсэн байна.

Бүлэг 2

*Дотоод хяналтыг зохих журмаар хэрэгжүүлж
ажилласан байна.*

2.1 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтын талаар

*Байгууллагын үйл ажиллагаанд зохих журмаар хяналт тавьж
ажилласан байна.*

Татварын хэлтэс нь тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндсэн 5 зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд 41 ажлыг төлөвлөж, жилийн эцэст биелэлтийг нь гаргаж, дүгнэж ажилласан байна. Жилийн эцэст Татварын хэлтсийн төлөвлөгөөний биелэлт 94,2 хувьтай дүгнэгдэж, байгууллагын төлөвлөгөөт ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Үүнд: хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, арга зүйг сайжруулах, холбогдох судалгаа санал зөвлөмжийг боловсруулах ажлын хүрээнд татварын зарим хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцож Сагсай Толбо, Дэлүүн, Булган, Улаанхус, Цэнгэл сумуудаар хууль сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчдөд сугалааны тохирлын журмын дагуу 10 иргэний баримтыг Татварын ерөнхий газарт хүргүүлж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулж ажиллажээ.

Татварын ногдуулалт, төлөлт, татвар хураах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллажээ.

Хувь хүний орлогын албан татварын тайланг хүлээн авч, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг буцаан олгох ажлыг зохион байгуулж, мэргэжлийн арга зүйгээр хангаж, татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулах ажлыг зохион байгуулж, Хэлтсийн үйл ажиллагааг олон нийтэд цахим хуудсаар нээлттэй хүргэх, ил тод болгох ажлыг зохион байгуулсан байна. Татвар төлөгчдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, хууль сурталчлах ажлыг зохион байгуулж,

татварын байцаагч нарын онлайн сурах боломжийг бүрдүүлэх болон бусад ажлуудыг хийж ирсэн байна.

2.2. Төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтын талаар

Өмч хөрөнгийн ашиглалт, төсвийн зарцуулалтад зохих түвшинд хяналт тавьж ажилласан байна.

Санхүүгийн нягтлан бодлох бүртгэлийг Татварын ерөнхий газрын системийн хэмжээнд хэрэглэдэг “Имералд” программыг ашиглан хөтөлж ирсэн байна.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн маягтыг зохих журмын дагуу хөтөлж, санхүүгийн баримтуудад 1, 2 дугаар гарын үсгийг хэлтсийн дарга, нягтлан бодогч нар зурж, баримтын бүрдэлтийг хангаж, санхүүгийн баримт материалыг цэгцтэй үдэж, баримтжуулсан байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, анхан шатны баримт материалын бүрдэлттэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй.

Хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлангаар 2 удаа тооллого хийж, үр дүнг баримтжуулсан байна. Жилийн эцсийн тооллого хийсэн комиссын хурлын тэмдэглэлд хуучирч элэгдлийн хугацаа нь дууссан 54 төрлийн 16,9 сая төгрөгийн хөрөнгийг актлах талаар тэмдэглэсэн байна.

Тус хэлтэс нь оны эхэнд 10,3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй ба 11,3 сая төгрөгийн материалыг худалдан авч, 1,4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 11,7 сая төгрөгийн материалыг зарцуулж, оны эцэст 11,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тус хэлтсийн үнэт цаас, тооцооны маягт нь нийт бараа материалын дүнд орж тооцогдож байгаа бөгөөд тайлант онд Ерөнхийг газраас 0,4 сая төгрөгийн үнэт цаасыг үнэ төлбөргүй хүлээн авчээ.

Оны эхэнд 393,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй ба 4,0 сая төгрөгийн хөрөнгийг нэмэлт санхүүжилтийн төсвөөр худалдан авч, 16,9 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг акталж бүртгэлээс хасаж, оны эцэст 380,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 20-ны өдрийн 194 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар тус Татварын хэлтсийн 16,9 сая төгрөгийн балансын үнэтэй УАЗ-469 /31519-595-01, 68-00 БӨА, арлын дугаар №70003630/ маркийн машиныг актлах шийдвэр гарсныг үндэслэн бүртгэлээс хассан байна.

Оны эцэст Нийгмийн даатгалын хэлтэс, Эрчим ХХК, Холбооны газар, Нур-Ернур ХХК, НИК, Мобиком корпораци, Монгол шуудан, Жансултан ХХК-иудтай тус тус тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, гүйцэтгэлийн аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Татварын хэлтэс нь батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

1. Татварын хэлтсийн бүтэц орон тоог баталж, ажиллаагүй байна.
2. Хэлтсийн үйл ажиллагааны төсвийг өмнөх оны гүйцэтгэлийг харгалзаж төлөвлөсөн байна.
3. Батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.
4. Нэмэлт төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2. Дотоод хяналтыг зохих журмаар хэрэгжүүлж ажилласан байна.

5. Байгууллагын үйл ажиллагаанд зохих журмаар хяналт тавьж ажилласан байна.
6. Өмч хөрөнгийн ашиглалт, төсвийн зарцуулалтад зохих журмаар хяналт тавьж ажиллажээ.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох албан тушаалтанд зөвлөмж өгөгдөөгүй байгаа болно.

Холбогдох байгууллагын санал

Татварын хэлтсээс ирүүлсэн санал:



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТЭС

ХЗ129 Өлгий, Өлгий сум, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: 7042-2385, E-mail: buyan_olgio@mta.gov.mn

2018-08-23 № 223
тантай 2018-07-11 -ны № 221 -г

БЯАН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2017 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Ямар нэгэн санал байхгүй байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т. ФЕСТИВАЛЬ

080359
D/Blank-A-5/

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР

АУДИТОР

Р.БАЯРМАА